

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, САНГИЙН САЙД, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,  
ХӨДӨЛМӨРИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2010 оны 04 дугаар  
сарын 00 -ны өдөр

Дугаар 143 / 87 / 48

Улаанбаатар хот


Даатгуулагчийг эрүүл мэндийн үзлэгт  
үнэ төлбөргүй үзүүлэх эрхээр урамшуулах  
зардлын хэмжээг тогтоох тухай

Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ НЬ:


Нэг. Дараалсан гурван жилийн хугацаанд эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний зардал гаргаагүй даатгуулагчийг нэг удаа эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулах зардлын нэг хүнд ногдох хэмжээг 22,000 /хорин хоёр мянга/ төгрөгөөр тогтоосугай.

Хоёр. Эрүүл мэндийн байгууллагад даатгалын сангаас олгох санхүүжилтийг энэ тушаалын нэгд заасан хэмжээгээр тооцож олгохыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Ч.Алтанхуяг/-т зөвшөөрсүгэй.

Гурав. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээ үнэлгээний газар /С.Энхболд/, Сангийн яамны Төсвийн бодлогын газар /Б.Батжаргал/, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Т.Энхтуяа/-т тус тус даалгасугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН  
САЙД  
  
С.ЛАМБАА

САНГИЙН  
САЙД  
  
С.БАЯРЦОГТ

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ  
ХӨДӨЛМӨРИЙН САЙД  
  
Т.ГАНДИ